

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/1/НА-СТА-ТӨА**

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр хот 2022 он	Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: gansukhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК” Утас: 70005711 Цахим хаяг: dulguunkhairkhanuulaudit09@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
4. Аудитын тайлан	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Дотоод хяналт	12
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
4.4 Материаллаг байдал	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Залруулсан алдаа	14
8.2 Зөвлөмж	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт

ХАРХОРИН УС СУВАГ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ё.ОТГОНСҮХ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,964,574.98	72,232,656.17
1.1.2	Дансны авлага	4,247,646.05	56,618,518.05
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	20,718,250.00	22,441,220.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	43,696,546.00	43,696,546.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10		-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	72,627,017.03	194,988,940.22
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	162,837,658.95	152,033,342.95
1.2.2	Биет бус хөрөнгө	33,600,000.00	33,600,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9		-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	196,437,658.95	185,633,342.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	269,064,675.98	380,622,283.17
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	25,888,929.67	11,572,168.35
2.1.1.4	НДШ-ийн өглөг	604,800.00	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12		-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	26,493,729.67	11,572,168.35
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр, төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5		-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	26,493,729.67	11,572,168.35
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	115,088,915.00	115,088,915.00

2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,958,092.35	25,958,092.35
2.3.7	Гадаад валютийн хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	107,296,546.00	107,296,546.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-5,772,607.04	120,706,561.47
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	242,570,946.31	369,050,114.82
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	269,064,675.98	380,622,283.17

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	208,575,634.10	426,496,060.06
2	Борлуулалтын өртөг	174,354,035.50	231,236,194.88
3	Нийт ашиг (алдагдал)	34,221,598.60	195,259,865.18
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	51,846,714.24	54,727,455.73
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-17,625,115.64	140,532,409.45
19	Орлогын татварын зардал	-	14,053,240.94
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-17,625,115.64	126,479,168.51
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-17,625,115.64	126,479,168.51
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
	Орлогын нийт дүн		
	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	115,088,915.00	-	-	133,254,638.35	-5,772,607.04	242,570,946.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл						
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	115,088,915.00	-	-	133,254,638.35	-5,772,607.04	242,570,946.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл						
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					126,479,168.51	126,479,168.51
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	115,088,915.00			133,254,638.35	120,706,561.47	369,050,114.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	272,722,205.45	515,329,463.76
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	272,722,205.45	515,329,463.76
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	275,346,285.82	447,061,382.57
	Ажиллагчдад төлсөн	91,456,245.00	110,242,824.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	29,122,037.07	35,822,133.54
	Бараа материал худалдан авахад төлсөн	-	-
	Ашиглалтын зардалд төлсөн	17,488,208.05	20,728,221.58
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,170,687.81	170,363,181.54
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	9,633,112.32	59,495,021.91
	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
	Бусад мөнгөн зарлага	115,475,995.57	50,410,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,624,080.37	68,268,081.19
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	-	-
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
		-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
		-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
		-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
		-	-

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-2,624,080.37	68,268,081.19
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,588,655.35	3,964,574.98
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,964,574.98	72,232,656.17

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2021 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	146,560,100.00	140,560,100.00	-6,000,000.00	95.9
2	Байгууллагаас төлөх ЭМНДШ	16,335,378.00	16,164,411.50	-170,966.50	98.9
3	Цахилгаан өөрийн хэрэглээ	14,881,650.00	20,728,221.60	5,846,571.60	139.3
4	Дулаан өөрийн хэрэглээ	-	-	-	-
5	Ус өөрийн хэрэглээ	-	-	-	-
6	Түлш, шатахуун тээврийн зардал	9,569,240.00	19,359,152.10	9,789,912.10	202.3
7	Албан томилолтын зардал	1,780,000.00	876,000.00	-904,000.00	49.2
8	Засвар, үйлчилгээний зардал	6,850,000.00	47,076,994.00	40,226,994.00	687.2
9	Ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	-	-	-	-
10	Конторын хангамжийн зардал	400,000.00	400,000.00	-	100.0
11	Хөдөлмөр хамгааллын зардал	1,932,498.80	1,887,204.00	-45,294.80	97.6
12	Харилцаа холбооны зардал	2,603,960.00	2,466,270.00	-137,690.00	94.7
13	Лаборатори, шинжилгээний зардал	-	-	-	-
14	Бичиг хэргийн зардал	800,000.00	852,842.00	52,842.00	106.6
15	ТҮЗ-ын зардал	-	-	-	-
16	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	12,720,915.20	12,720,316.00	-599.20	99.9
17	Зохицуулалт үйлчилгээний хөлс	1,001,300.00	1,383,400.00	382,100.00	138.1
18	Гадны үйлчилгээний хөлс	3,150,000.00	7,302,565.40	4,152,565.40	231.8
19	Татварын зардал	1,218,911.00	2,955,247.00	1,736,336.00	242.4
20	Даатгалын зардал	191,250.00	196,350.00	5,100.00	102.6
21	Үйл ажиллагааны бусад зардал	5,616,800.00	4,304,665.00	-1,312,135.00	76.6D
22	Ажиллагсдын нийгмийн зардал	4,350,000.00	3,123,900.00	-1,226,100.00	71.8
23	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-	-
24	Худалдан авалт: Цахилгаан	-	-	-	-
25	Дулаан	-	-	-	-
26	Цэвэр ус	-	-	-	-
27	Бохир ус	-	-	-	-
28	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	888,416.00	3,606,012.10	2,717,596.10	405.9
	БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ЗАРДАЛ	230,850,419.00	285,963,650.70	55,113,231.70	123.9
	ОРЛОГО				
1	Усны борлуулалтын орлого	230,850,419.00	426,496,060.10	195,645,641.10	184.7
	Усны хэсгийн бусад орлого	-	-	-	-
2	Дулааны борлуулалтын орлого	-	-	-	-
	Дулааны хэсгийн бусад орлого	-	-	-	-
3	Цахилгааны борлуулалтын орлого	-	-	-	-
	Цахилгаан хэсгийн бусад орлого	-	-	-	-
4	Бусад орлого	-	-	-	-
5	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	-	-	-
	ОРЛОГЫН ДҮН	230,850,419.00	426,496,060.10	195,645,641.10	184.7
	АШИГ+, АЛДАГДАЛ-	-	140,532,409.40	140,532,409.40	-

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын зорилго нь Хархорин сумын хүн ам, албан байгууллага, аж ахуйн нэгжийг унд ахуйн стандартын шаардлагад тохирсон цэвэр усаар хангах, бохирдсон усыг татан зайлуулах үйлчилгээг найдвартай түргэн шуурхай үзүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цэвэр усан хангамж, бохир ус татан дамжуулах, ариутгах, цэвэр усны алдагдлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, цэвэр, бохир усанд стандартын шаардлагын дагуу лабораторийн шинжилгээ хийх, барилга байгууламжийг цэвэр, бохир усны сүлжээнд холбох, усны тоолуурын туршилт тохируулгын ажил гүйцэтгэх түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 100 хувийн орон нутгийн өмч статустай байна.Төлөөлөгч хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, аймгийн өмчийн газар, аймгийн ИТХ байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хархорин ус суваг ОНӨААТҮГ нь Өвөрхангай аймгийн ИТХ Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын 13-ны 89 тоот тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 150.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд зохистой арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж , чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт, шинэчлэлт гараагүй.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,964.6	72,232.7	68,268.1
БХХО	-	-	-
Авлага	4,247.6	56,618.5	52,370.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	20,718.3	22,441.2	1,722.9
Бусад эргэлтийн хөрөнгө	43,696.5	43,696.5	-
Үндсэн хөрөнгө	162,837.7	152,033.4	-10,804.3
Биет бус хөрөнгө	33,600.0	33,600.0	-
Нийт хөрөнгийн дүн	269,064.7	380,622.3	111,557.6
Өр төлбөрийн дүн			
Богино хугацаат өглөг	26,493.7	11,572.2	-14,921.5
Урт хугацаат өглөг	-	-	-
Эздийн өмч	242,571.0	369,050.1	126,479.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	269,064.7	380,622.3	111,557.6

Касс дахь бэлэн мөнгө 29.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд Хаан банкинд 71,644.4 мянган, Хас банкинд 559.3 мянган төгрөг тус тус байна.

Авлагын үлдэгдэлд Дансны авлага буюу нэгдсэн эмнэлэгээс авах авлага 7,647.9 мянган төгрөг, Гурван тамир худалдааны төвөөс 66.8 мянган төгрөг, Ган илч дулаан ХХК-иас 2,524.5 мянган төгрөг, ХСУХАТАҮЗЗөвлөлөөс 46,379.3 мянган төгрөг нийт 56,618.5 мянган төгрөг байна.

Тайлант онд ХСУХАТАҮЗЗөвлөлөөс авах авлага 20,730.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 22,441.2 мянган төгрөг болж 1,723.0 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд үндсэн хөрөнгө шинээр 4,916.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, Өвөрхангай аймаг орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр 9,722.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 1,000.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан, 36,600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан нийт 46,322.3 мянган төгрөгийн хөрөнгө акталсан.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд ХХОАТ-ын 3,128.2 мянган төгрөг, НӨАТ-ын 8,443.9 мянган төгрөгийн өр төлбөр байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 2,880.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цалингийн зардлаас шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цэвэр болон бохир усны зардлуудыг хамруулсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын ТУЗөвлөлийн 2021 оны 03 дугаар тушаалаар 2021 оны компанийн санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 230,850.4 мянган төгрөгөөр, нийт зардлыг 230,850.4 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 426,496.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 285,963.6 мянган төгрөгийн зардал гарган, 140,532.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 426,496.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 195,645.6 мянган төгрөг буюу 184.7 хувиар давсан нь Монгол улсын засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны 211 дугаар тогтоол “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэх үзүүлэх тогтоол” үүнээс үүдэн албан байгууллага айл өрхийн усны хэрэглээний хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 285,963.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 55,113.2 мянган төгрөг буюу 123,8 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь засвар, үйлчилгээний зардал, түлш, шатахуун, тээврийн зардал нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу бохир ус татан зайлуулах автомашин экскаватор засварлах ажилд өөрийн эх үүсвэрээс засварын зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 126,479.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 126,479.2 мянган төгрөгөөр илүү байгаа нь Монгол улсын засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны 211 дугаар тогтоол “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэх үзүүлэх тогтоол” үүнээс үүдэн албан байгууллага айл өрхийн усны хэрэглээний хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлж байна.

Тайлант онд 54,727.5 мянган төгрөгийн ерөнхий ба удирдлагын зардал гарсан байна. Үүнээс

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад ажиллагсдад олгосон түлээ, нүүрсний хөнгөлөлтөөс хувь хүний орлогын албан татвар авах, цалин хөлс, НДШ, ХХОАТ-ын тооцоолол зөв тооцоолох, шилэн дансны мэдээллийг бүрэн тусгах, дүрмийн сангийн өөрчлөлтийг оруулах, програм хангамжаа сайжруулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёр дугаар газрын /Дөлгөөнхайрхан уул аудит ХХК-ийн/ аудитор Э.Нарангэрэл, аудиторын туслах Д.Эрдэнэтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Пүрэвдулам нар тус тус хэрэгжүүлсэн.

Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 0102 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хархорин ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн

тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 65,135.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,302.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хархорин ус суваг ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шиидвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн тайлант онд 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 14,869.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, албан шаардлага 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	14,869.0	2	14,869.0	-	-	-
Нийт дүн	2	14,869.0	2	14,869.0	-	-	-

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал нь шууд бус орлогуудаас татвар суутган авсан эсэхийг тулган шалгах.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 112,180.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 112,163.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 112,163.6 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 1,094.5 мянган төгрөгийн түвшинээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 16.5 мянган төгрөгийн Хувь хүний орлогын албан татварын тайлантай холбоотой алдааг залрууллаа. Үүнд:

- Нийт 7 хүний цалингийн хувь хүний орлогын албан татварын суутгалын зөрүүнүүд болох 16.5 мянган төгрөгийн алдааг тулган шалгаж залруулсан
- Энэ нь “Үнэн зөв байх болон иж бүрэн байх батламж” мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дансны үлдэгдэл-Богино хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажилчдад олгосон түлээ, нүүрсний хөнгөлөлтөөс 11 сарынх дээрээ суутгалуудаа авсан боловч 2 сард олгосон 900,000 төгрөгөөс суутгал аваагүй олгосон байна.

Өгсөн зөвлөмж:

Тус компани нь шууд бус орлого буюу ажилчдад олгосон түлээ, нүүрсний хөнгөлөлт хандив тусламжаас суутгалуудыг авч цаашид хэрэгжүүлж ажиллах.

2. Дансны үлдэгдэл-Богино хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн хувьд 40 кодтой буюу давхар ажил эрхэлж буй хүнийг ХХОАТ-ын хөнгөлөлт тооцсон, тэтгэврийн хүний НДШ-ын хувийг зөрүүтэй тооцоолсон. Мөн ТТ-11 буюу Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын тайлан дээр ХХОАТ-ын хөнгөлөлт, 40 кодтой мөн 22 кодтой хүмүүсийн НДШ-ийн хувийг буруу тооцоолсон.

Өгсөн зөвлөмж:

Цаашид нийгмийн даатгалын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжуудын дагуу цалингийн тооцоолж, нягтлан тулгаж байх.

3. Тодруулга-Засгийн газрын хувь оролцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн/ гүйцэтгэл 3 тайлан огт оруулаагүй үүнээс санхүүгийн тайлангийн аудит нь дуусгавар болох болоогүй мөн 4 тайлан хоцорсон, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтаас огт оруулаагүй 1, хоцорсон 4 тайлан, бусад 5 хоцорсон тайлан буюу нийтдээ 4 огт оруулаагүй, 13 хоцорсон тайлан байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн дагуу цаг хугацаанд нь заавар журмын дагуу мэдээллүүдээ мэдээлж байх.

4. Тодруулга-Засгийн газрын хувь оролцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Анх үүсгэн байгуулагдахад дүрмийн сан 3,064.0 мянган төгрөг байсан 2021 оны тайлант жил 115,088.9 мянган төгрөг болсон байна. Дүрмийн сан 2016 оноос хойш нэмэгдсэн байна. Тус дүрмийн сангийн өөрчлөлтүүдийг одоог хүртэл Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт хийгдээгүй явж байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүү, төрийн сангийн дүрмийн сан өөрчлөгдсөн тайлангаа баталгаажуулан дүрмийн сангийн өөрчлөлтийг цаг тухайд нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт хийлгэж байх.

5. Тодруулга-Биет бус хөрөнгө холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага “Microsoft excel” програм ашигладаг. Тайлангийн бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тус компанийн Санхүүгийн тайлангийн бүртгэл хөтлөлт хангалтгүй иймээс цаашид тайлангийн бүртгэл хөтлөлтөө сайжруулж санхүүгийн програм хангамж авч ажиллах. Програм хангамжаа сайжруулан ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

/мянган төгрөгөөр/

[illegible]

Хархорин ус суваг ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			жил 115,088.9 мянган төгрөг болсон байна. Дүрмийн сан 2016 оноос хойш нэмэгдсэн байна. Тус дүрмийн сангийн өөрчлөлтүүдийг одоог хүртэл Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт хийгдээгүй явж байна.	байх, Дүрмийн санд өөрчлөлт орох бүрд өөрчлөлтийг хийлгэх												
5	Хархорин ус суваг ОНӨААТҮГ	ӨВА-2022/1/НА-СТА-ТӨА	Тус байгууллага "Microsoft excel" програм ашигладаг. Тайлангийн бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.	Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 47 тоот тушаал "Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн програмд тавигдах шаардлага"-ыг мөрдөж ажиллах, програмаа сайжруулах	1	-									1	-
ДҮН					5	112,163.6									5	112,163.6
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
ДҮН																
НИЙТ ДҮН					5	112,163.6									5	112,163.6